



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 01/386

Улаанбаатар хот

Б.Энхмэндэд сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 5.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1, 10.2, 10.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Баярхүүгийн Энхмэнд нь үүрэгт ажилдаа хайнга хандаж, Улсын бүртгэлийн хууль, тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж ажиллаагүй нь Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 2788 дугаар дүгнэлтээр тогтоогдсон тул түүнд албан тушаалын цалингийн хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Энхмэндэд үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Б.Төгс-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГӨРСАЙХАН



142401647